

Ховд аймаг - хууль бус агнуур

Докторант М.Отгонбаатар, Ховд Их Сургууль, Биологийн тэнхим

Хянасан. Ё.Онон, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Зорилго : Монгол улсын баруун хэсэгт орших Ховд аймгийн ард иргэд хууль бус агнууртай холбогдох Ан агнуурын болон Амьтны аймгийн тухай хуулийн талаар хэр мэдлэг мэдээлэлтэй байгаа, хууль бус агнуур хэр байгааг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Үндэслэл:

1. Хууль бус агнуур, түүнийг багасгах арга замыг хайх, эрж олох;
2. Ард иргэд Амьтны аймгийн тухай болон Ан агнууры тухай хуулийн талаар хэр их мэдлэг, мэдээлэлтэй байгааг судлаж мэдэх. Ингэснээр цаашид ямар чиглэлээр, юуны тухай сурталчилгаа, мэдээлэл хийж болохыг тодорхойлох;

Судалгааны арга зүй: Судалгааг 2007оны 4-н сарын 5- наас 15-ыг хүртэл 10 хоногт Ховд аймгийн **Баруун монгол** төв зах , таксины зогсоол, 11 жилийн 2-р дунд сургууль, Жаргалан багийн өрхийн эмнэлэг, Их буян зах зэрэг газруудад төвлөрч ард иргэдээс **урьдчилан боловсруулсан доорх асуултын дагуу** судалгаагаа авсан.

1. Ямар амьтныг агнаж болохгүй вэ?
2. Хууль бус агнуур хэр их байдаг вэ?
3. Хууль бус ангийн түүхий эдийг хаана худалдаалдаг вэ?
4. Хууль бус анг ямар хүмүүс хийдэг вэ?
5. Ан амьтан хамгаалах хамгийн сайн арга аль нь вэ?
6. Хориотой ан агнавал ямар хариуцлага хүлээх вэ?
7. Ан агнах зөвшөөрлийг ханаас авч болох вэ?

Бидний судалгаанд эмч, багш, сахиул, жолооч, хувиараа бизнес эрхлэгч, ажилгүй зэрэг нийт 193 хүн судалгаанд хамрагдсан.

Судалгааны үр дүн: Судалгааны дүнгээс үзэхэд (I) **“Ямар амьтныг агнаж болохгүй вэ?”** гэсэн асуултанд нийт 193 хүнээс давхардсан тоогоор 110 аргаль хонь, 99 хүн нь ирвэс, 77 нь янгир ямаа, 33 нь бөхөн, 31 нь хулан , 30 нь тахь, 26 нь цагаан зээр гэх мэтийн зэрэг нийт 36 амьтны нэрс бичсэн байлаа (график 1).





График 1. Агнахыг хуулиар хориглосон амьтдын талаар ард иргэдийн өгсөн дүн

(II) “Танай нутагт хууль бус агнуур хэр их байдаг вэ?” гэсэн асуултанд нийт 193 хүнээс маш их гэж 45, их гэж 79, дунд зэрэг гэж 66, бага гэж 7, байхгүй гэж 2 хүн хариулсан байна (график 2).






График 2. Хууль бус агнуур тухайн нутагт хир хэмжээтэй байгааг үнэлсэн дүн

(III) “Аа амьтны гаралтай түүхий эдийг хаана худалдаалдаг вэ?” гэсэн асуултанд бараан зах гэж 64 хүн, дэлгүүр гэж 2, хувь хүмүүс хоорондоо гэж 68 хүн, нууцаар хийгддэг учраас мэдэхгүй гэж 86 хүн тус тус хариулсан байна (график 3).

График 3. Ангийн гаралтай түүхий эдийн худалдааны цэгүүдэд өгсөн үнэлгээ

(IV) “Хууль бус агнуурыг ямар хүмүүс хийдэг вэ?” гэсэн асуултанд нутгийн иргэд гэж 66, эрхэлсэн ажилгүй залуус гэж 52, хүн бүхэн гэж 31, мэргэжлийн цөөхөн хүмүүс гэж 37, том тушаалтан дарга нар гэж 67, гадаадын иргэд гэж 53 хүн хариулсан байна (график 4).




График 4. Хууль бус агнуурыг ямар хүмүүс хийдэг талаар өгсөн үнэлгээ

(V) “Ан амьтан хамгаалах хамгийн сайн арга аль нь вэ?” гэсэн асуултанд уламжлалт аргаар гэж 15, нутгийн ард иргэд нөхөрлөл байгуулж гэж 99, мэргэжлийн болон хууль хяналтын байгуулагууд гэж 53, тусгай арга боловсруулах замаар гэж 33, сургалт сурталчилгаа сайн хийж гэж 48 хүн тус тус хариулжээ (график 5).




График 5. Ан амьтныг хамгаалах арга зүйд өгсөн үнэлгээн

(VI) “Хориотой ан агнавал ямар хариуцлага хүлээх вэ?” гэсэн асуултанд

1. Торгуул ба нөхөн төлбөр гэж 90 хүн
2. Хуулийн хариуцлага хүлээнэ гэж 40 хүн
3. Мэдэхгүй гэж 38 хүн

4. Эрүүгийн хариуцлага хүлээнэ гэж 13 хүн
5. Ял шитгүүлнэ гэж 12 хүн хариулж бичжээ (график 6)




График 6. Ан агнуурын тухай хуулийн талаарх ар иргэдийн мэдлэгт өгсөн үнэлгээ

Сүүлийн асуулт болох (VII) “**Ан агнах зөвшөөрлийг хаанаас авч болох вэ?**” гэсэн асуултанд БОЯ-аас гэж 66 хүн, тухай оршин суугаа газрын БОЯ –аас гэж 13, төрийн захиргааны байгуулгаас гэж 9, мэдэхгүй гэж 82, ойн байцаагчаас гэж 2 ангийн нийгэмлэгээс гэж 6, хууль, хяналтын байгууллагаас гэж 8, засаг даргаас гэж 7 хүн тус тус хариулсан байна (график 7).

Ан агнах зөвшөөрлийг хаанаас авч болох вэ




График 7. Ан агнуурын тухай хуулийн талаарх ар иргэдийн мэдлэгт өгсөн үнэлгээ

Дүгнэлт:

Асуулгын судалгаанаас үзэхэд агнаж болохгүй амьтанд хамгийн их санал авсан нь Аргаль хонь 110 (56.9%), Цоохор ирвэс 99 (51.2%), Янгир ямаа 77 (39.8%) байна. Иргэд эдгээр нэн ховор болон ховор амьтдыг хуулиар агнахыг хориоглосон гэдгийг тодорхой хэмжээгээр мэдэж байна. Үүнийг дээрх ан амьтдын нөхөн төлбөр, хариуцлага статустай холбоотой мэдээ мэдээлэл сайтай байгааг харуулж байна. Хууль бус агнууртай тэмцэх Ирвэс багийн сүлжээ баруун аймгуудад эдгээр амьтдад тулгуурлан сурталчилгаа явуулдагтай шууд холбоотой. Борцгор хотон нь хуулиар өндөр статустай амьтанд хамрагддаг. Гэтэл судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын дөнгөж 9 хүн (4.6%) энэ амьтны талаар мэдэж байна. Энэ нь энэ зүйл амьтны талаар харьцангуй мэдээлэл багатай байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл тухайн амьтны ард иргэд төдийлөн сайн мэдэхгүй байгаа нь харагдаж байна

Хууль бус агнуур их гэж 79 (40.9%) санал, дунд зэрэг гэж 66 (34.1%), маш их гэж 45 (23.3%) санал өгсөн байгаа нь Ховд аймагт магадгүй хууль бус агнуурын түвшин их байна гэдгийг харуулжээ. Үүнийг олон зүйлтэй холбон тайлбарлаж болох юм. Үүнд:

1. Сургалт сурталчилгаа дутмаг
2. Хуулийн хэрэгжилт сул
3. Хамгаалах арга замыг оновчтой сонгоогүй
4. Мөн байгаль хамгаалагч, байгаль орчны асуудал хариуцсан ажилтан нутгийн ард иргэдийн уялдаа, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа гэх мэт олон шалтгаантай.

Мөн ан амьтны гаралтай түүхий эдийг хаана худалдаалдаг вэ? гэдэг нь нууцаар учраас мэдэхгүй гэж 86 хүн буюу 44.5% нь хариулсан байна. Эндээс үзэхэд ан амьтны гаралтай

түүхий эдийг худалдаалдаг хүмүүс нууц сүлжээг бий болгож бүтээгдэхүүнээ наймаалцдаг байна.

Ер нь хууль бус анг ямар хүмүүс хийж байна вэ? гэдэг асуултанд албан тушаал өндөр дарга нар гэж 67 хүн буюу 34.7%, нутгийн ардууд гэж 66 хүн буюу 34.1% нь хариулжээ. Тодорхой албан тушаал бүхий дарга нар хамгийн их хувийг эзэлж байгаа нь эдгээр хүмүүсийн хуулийг хэрэгжүүлэх байдал сул, тэдгээрт хууль үйлчилдэггүй, аль эсвэл хоорондоо хувилдах авилга, хээл хахууль өгч авалцах, албан тушаалаа ашиглаж, төрийн машин, бензинээр туйлж хууль бус агнуур хийдэг тул хууль зөрчдөг гол субъект болж байна.

Судалгааны гол зорилго хууль бус агнуурын өнөөгийн түвшин хэр байгааг судалж үзэх, мөн хууль бус агнуурыг таслан зогсоох, багасгах арга замыг эрэлхийлэх зорилгыг агуулж байсан.

Энэ асуултад нутгийн байгалийн нөөцийг зохистой ашиглах нөхөрлөл байгуулах замаар гэж 99 (51.2%) хүн, мэргэжлийн болон хууль хяналтын байгуулагийн чадвар, уялдааг сайжруулах гэж 53 (27.4%) хүн, сургалт сурталчилгааг сайжруулах замаар гэж 48 (24.8%) хүн хариулсан байна. Энэ нь ард иргэд нөхөрлөл байгуулж байгаль хамгаалахын ач тусыг маш сайн мэдэрсэн бөгөөд хэдийгээр өнөөдөр сайн туршлага болоогүй ч гэсэн цаашид энэ арга үр дүнтэй болохыг харуулж байна.

Хуулиар агнахыг хориглосон ан агнавал ямар хариуцлага хүлээх вэ? гэсэн асуултанд:

- Торгуул ба нөхөн төлбөр
- Хуулийн хариуцлага хүлээнэ
- Эрүүгийн хариуцлага хүлээнэ
- Мэдэхгүй г.м хариултыг өгсөн байна .

Энэ тал дээр ард иргэд зарим нь мэдэхгүй, мэдсэн ч хүлээх хариуцлага хуулийн хэрэгжилт муу байгаагаас тоомсоргүй байдлаар хандаж байгальд ихээхэн хохирол учруулж байна.

Ан агнах зөвшөөрлийг хаанаас авч болох вэ? гэсэн асуултанд :

- БОЯ
- Орон нутгийн байцаагч
- Төрийн захиргааны байгуулага
- Мэдэхгүй г.м хариултыг өгсөн байна.

Мэдэхгүй гэж 82 хүн буюу 42.4% нь хариулсан байна. Энэ талаарх хууль эрх зүйн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна.